



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 8/24

Улаанбаатар хот

Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй хавсралтад заасан нийт 11,100,170.00 (арван нэгэн сая нэг зуун мянга нэг зуун дал) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянгол, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газруудын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (О.Ганбат)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн Цагдаагийн газар (Ч.Алтанхуяг)-т, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Ц.Амгалан-Энх)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500283

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2024 оны ... дугаар сарын ... өдрийн
 ... дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн Цагдаагийн удирдах газар

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдс ан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага	төгрөгөөр
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	
Машин, тоног төхөөрөмж											
1	Таблет 256gb	2023	ш	1	2,630,130.0	2,630,130.0		2,630,130.00	Нийслэлийн Цагдаагийн удирдах газар	Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар	
	Дүн			1	2,630,130.0	2,630,130.0	-	2,630,130.0			
Машин, тоног төхөөрөмж											
2	Процессор dell opti	2023	ш	2	3,098,360.0	6,196,720.0	826,229.3	5,370,490.67	Нийслэлийн Цагдаагийн удирдах газар	Баянгол дүүргийн Цагдаагийн газар	
3	Дэлгэц dell 24 monitor	2023	ш	2	588,510.0	1,177,020.0	156,936.0	1,020,084.00			
4	Принтер canon	2023	ш	1	598,740.0	598,740.0	79,832.0	518,908.00			
5	Принтер hp lazer	2023	ш	1	497,560.0	497,560.0	63,341.3	434,218.66			
	Дүн			6	4,783,170.0	8,470,040.0	1,126,338.7	7,343,701.3			
	Нийт хөрөнгийн дүн			7	7,413,300.0	11,100,170.0	1,126,338.7	9,973,831.3			